

Улаанбаатар Цэвэр агаар төслийн хүрээнд гэр хороолол дахь байшин сууцуудын дулаан алдагдлыг бууруулах зорилгоор “Дулаалгын аян-3” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд дулаан тусгаарлалтын ажилд хяналт тавих хүсэлтэй хувь хүн болон багийг шалгаруулалтад урьж байна.

Танилцуулга:

Энэхүү туршилтын төслийн зорилго нь гэр хороололд амьдардаг айл өрхүүдэд байшин сууцаа дулаалахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар дулааны алдагдлаа бууруулах, нүүрсний хэрэглээгээ багасгах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, улмаар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжийг олгож байгаад оршиж байгаа болно.

Байшин сууцаа дулаалахаар хүсэлтээ ирүүлсэн нийслэлийн 6 дүүргийн 100 орчим айл өрхийг дулаалгын ажлаа өөрсдийн гараар хийхэд нь мэргэжлийн заавар зөвлөгөө өгч сургах, биечлэн хийж үзүүлэх, чанарын хяналт тавихад хяналтын инженерүүд болоод баг хамт олны үүрэг оршино.

Ажлын цар хүрээ

Ажлын цар хүрээ нь дараахи үндсэн даалгавраас бүрдэнэ.

- 1, Айл өрхүүдийн байшингийн дулаалгын хэмжээг гаргах
- 2, Айл өрхүүдэд мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх
- 3, Шаардлагатай үед газар дээр нь биечлэн үзүүлэх, хяналт тавих
- 4, Дулаалгын материалд чанарын хяналт хийх

Даалгавар 1-ийн хүрээнд

- ТУН-ийн бүртгэлд хамрагдсан, сонирхлоо илэрхийлсэн айл өрхийн байшинг газар дээр нь очиж дулаалгын ажлын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлах
- Шаардлага хангасан байшин сууцнуудын дулаалах талбайн хэмжээг гаргах
- Шаардлага хангасан айлуудын судалгааг бөглөн, нэгтгэн ТУН-д тайлагнах

Даалгавар 2-ын хүрээнд

- Үйлдвэрлэгийн ирүүлсэн нийлүүлэлтийн хуваарийг айлуудад урьдчилан мэдэгдэж бэлтгэл хангуулах.
- Шаардлагатай багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсыг бэлтгүүлэх
- Айлуудтай тохирсон дулаалгын ажлыг гүйцэтгэх хуваарийг ТУН-д гаргаж өгөх
- Буулгасан материалыг гадны нөлөөллөөс /бороо усанд автах, хулгайд алдах, бусдад зарж үрэх/ хамгаалах заавар өгч, үүнээс гарах хариуцлагын тогтолцоог ойлгуулах
- Хуваарийн дагуу айлд очин дулаалгын ажлыг гүйцэтгэх сургалтыг газар дээр нь өгөх

Даалгавар 3-ын хүрээнд

- Дулаалгын ажил гүйцэтгэх туршлагагүй, мэргэжлийн хүнгүй айлд дулаалах ажлыг биечлэн үзүүлнэ.
- Дулаалах ажлыг технологийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавина
- Дулаалгын ажлын үе шат бүрийг фото зургаар баталгаажуулан, гүйцэтгэлийн актыг баталгаажуулан ТУН-д тайлагнана.

Даалгавар 4-ийн хүрээнд

- Дулаалгын аянд хамрагдах хүсэлтээ ирүүлсэн материал үйлдвэрлэгч нь хүчин чадал, хүний нөөц, хөдөлмөр, аюулгүй байдал талаасаа шаардлагад нийцэж байгаа эсэхэд үйлдвэр дээр нь очиж хяналт хийнэ. ТУН-д тайлагнана.
- Дулаалгын материал нь чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхэд стандартын дагуу хяналт тавина. ТУН-д тайлагнана.
- Сонгогдсон айлд хүргэгдсэн материал нь чанарын шаардлагад хангасан эсэхэд хяналт тавьж хүлээн авна. Үйлдвэр дээрхээс өөр материал нийлүүлсэн тохиолдолд буцаах эрхтэй бөгөөд буцаалтын тухай ТУН-д мэдэгдэнэ.

Хяналтын инженер эсвэл баг хамт олонд тавигдах шаардлага

- Барилгын инженер эсвэл халаалт салхивчийн чиглэлээр их дээд сургууль төгссөн байх
- Барилгын талбайн удирдлага, хяналтаар эсвэл чанарын инженерээр ажиллаж байсан туршлагатай байх
- Барилгын эрчим хүчний хэмнэлт, дулаан алдагдал, гэр хороолол дахь байшин сууцнуудын хийц, асуудлын талаар мэдлэгтэй байх
- Барилга байгууламжийн гадна фасад, дулаан тусгаарлалтын ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай байх
- Гэр хорооллын нөхцөл байдлыг сайн мэддэг, гэр хорооллын иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай, нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүстэй харьцах арга барилыг эзэмшсэн, багаар ажиллах чадвартай байх
- Тээврийн хэрэгсэлтэй, түүгээрээ үйлчилгээ үзүүлэх боломжтой байвал сайн
- Хэд хэдэн инженерүүд баг болж оролцох боломжтой.

Удирдлага, хамтын ажиллагаа

Улаанбаатар Цэвэр агаар төслийг удирдах нэгж /ТУН/ нь сонгогдсон хяналтын инженерүүд болон багийг удирдлагаар ханган хамтран ажиллана.

ТУН нь Хяналтын инженерүүд/баг-т дараах мэдээллийг өгч сургалт явуулна. Үүнд

- Дулаан алдаглын хэмжилт хийгдсэн 100 айлын байршил, зураглал, дулаан тусгаарлалтын зөвлөмж
- Төсөлд хамрагдах үйлдвэрлэгчид болон бүтээгдэхүүнд тавигдах шалгуур үзүүлэлтүүд
- Дулаалгын ажлыг хянах, гүйцэтгэх арга аргачлалын талаар сургалтад хамруулна
- Шаардагдах стандартууд болон бусад техникийн мэдээллээр хангана

Төслийн хугацаа

“Дулаалгын аян” туршилтын төсөлд хяналт хийх хугацаа нийтдээ 3 сар байх ба 2019 оны 3-р сар эхэлж 2019 оны 6 сарын 15-нд дуусна.